



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/117.

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32., 32.1.3, 32.1.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг дарга, Монгол Улсын Шадар сайдтай байгуулсан гэрээний дагуу Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт аймгийн хэмжээнд зохион байгуулагдах болсон тул сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн техник, хэрэгслийг шалгаж гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийхэд сумын шуурхай штаб, мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, ажиллах боломж нөхцөлөөр хангахад үлээгч аппарат, орчин үеийн ажиллагаа сайтай жижиг оврын цахилгаан үүсгүүр зэрэг нь шаардлагатай, бэлэн байдлын улсын үзлэгт бэлдэх зохион байгууллалтын арга хэмжээнд шатахууны зардал тусгах шаардлагатай байх тул дээрх үйл ажиллагааны зардалд зориулж 10 091 300 (арван сая ерэн нэгэн мянга гурван зуун) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Гамшгийн эрсдлийг бууруулах сангийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР